

**МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХ
ЭМЧЛЭХ, ЭМ БАРИХ, СУВИЛАХ, ЭХ БАРИХ, СЭРГЭЭН ЗАСАХ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ БАГЦ ЦАГ БИЕЛҮҮЛЖ СУНГУУЛАХАД
ДАРААХЬ МАТЕРИАЛЫГ БҮРДҮҮЛНЭ. ҮҮНД:**

1. Өргөдлийн маягт
2. Байгууллагын албан тоот */ажил эрхэлдэггүй бол хувь хүний өргөдөл/*
3. Боловсролын дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулна/
4. Иргэний үнэмлэхний хуулбар
5. Хугацаа дуусах лиценз */эх хувиараа/*
6. Багц цаг бүрдүүлэлтийн тайлангийн маягтыг доорхи хүснэгтээр гаргаж компьютерээр шивнэ.

Энэхүү тайланг *багц цагийн гэрчилгээний хуулбарын* хамт он тус бүрээр үдэж бүрдүүлнэ.

7. 3x4 хэмжээтэй зураг 2 хувь

8. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт: 5000 төг

Татварын Ерөнхий газраас Тэмдэгтийн хураамж төлөх дансыг нэгтгэсэн тул та ТЕГ-ын www.mta.mn сайт уруу орон E-TAX.MTA.MN татварын цахим системд нэвтрэн **Төлбөрийн даалгавар үүсгэх** хэсгээр орж асуултуудыг бөглөн **Хадгалах** товчийг дарснаар гарч ирэх **КОД**-ыг авч аль ч банкинд очин төлөх боломжтой болсныг мэдэгдье.

9. Эрүүл мэнд, спортын сайд 2015 оны “ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” /эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох /98 дугаар тушаалын 1.5 дахь заалтад хамрагдсан 25 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүд дээрх материалаас гадна хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, ажлын газрын тодорхойлолтыг хавсаргана.

Жич: Нийгмийн даатгалын дэвтрийн зурагтай нүүр хэсэг анх ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаалтай хэсгийг тоолоход 25 ба түүнээс дээш жил болсон байна гэж нотлогдох тул материалд хуулбарлан хавсаргах

10. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа Монгол Улсын Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, тухайн мэргэжлээрээ 25 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний ажлын газрын

тодорхойлолт, ажлын тайланг үндэслэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгана. */ЭМС-ын 2019 оны А/492 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт/*

11. Зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө дээрхи материалуудыг бүрдүүлэн ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагынхаа хүний нөөцийн ажилтнаар эсвэл өөрийн биеэр Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн төлөвлөлт хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн 216 тоот өрөөнд авчирч өгнө.

ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР